



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН  
БИЕЙН ТАМИР, СПОРТ ХОРООНЫ  
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/37

Улаанбаатар хот

┌ Тэмцээний зардал гаргах тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, "Биеийн тамир, спортын тухай" хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, 34 дүгээр зүйлийн 34.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дүүргийн өсвөр үеийн шигшээ багийн чөлөөт бөхийн тамирчин Лхагвасүрэнгийн Эрдэнэбулган Азийн аварга шалгаруулах тэмцээнд 2025 оны 06 дугаар сарын 22-ноос 24-ний өдрүүдэд Вьетнам улсын Вунгтау хотод болох тэмцээний U17 насны 66 кг жингийн ангилалд оролцуулсугай.

2. Тэмцээний тээврийн зардалд 500,000 (Таван зуун мянга)-н төгрөгийг нэмэлт санхүүжилтийн зардлаас гаргахыг Нягтлан бодогч (П.Бат-Оюун)-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Спортын хэлтсийн дарга (Ю.Батсайхан)-д даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Э. БАТХҮҮ